



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 1/284

Улаанбаатар хот

“Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа”
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох,
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3.1, 19.3.4, 19.5.3, 19.21, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн газрын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн яам төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/1126 дугаартай чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдүүдийг 2025 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн даргын зөвлөлийн хуралд танилцуулсны дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 3 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийг түр түдгэлзүүлэх 1 хуулийн хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж, эмч, мэргэжилтний чадавхийг сайжруулан, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахыг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож, харьяа дүүргийн татварын байгууллагад мэдэгдэн, мэдээллийг цахим хуудаст байршуулахыг тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Жаргал үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл авснаас хойш үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-д, тайлан, мэдээг хууль, журмын дагуу хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийх, шинээр тусгай зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг газрын тайлан мэдээний санд оруулж, баяжуулалт хийн ажиллахыг Төлөвлөлт, хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Д.Сайнхүү)-д нарт тус тус даалгасугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БЯМБАДОРЖ

משרד המשפטים
מחלקת המשפטים



9077456 CTC5592 9034120792

(המשרד) משרד המשפטים, מחלקת המשפטים, משרד המשפטים...
...משרד המשפטים, מחלקת המשפטים, משרד המשפטים...
...משרד המשפטים, מחלקת המשפטים, משרד המשפטים...

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
 2025 оны 08 дүгээр сарын 16-ны өдрийн
 А/284 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
 ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /Регистрийн дугаар/	Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлөөр эзэмших үйлчилгээний чиглэл	Хаяг
1.	Их манал ХХК /7187265/	Эмийн сан	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	СХД, 19-р хороо, 21-р хороолол, 18081, Үйлчвэрчний эвлэлийн гудамж, 90А байр, 1 давхар, 100б
2.	Өгөөмөр алтан нар ХХК /8416125/	Эмийн сан	Хоёрдугаар зэрэглэлийн эмийн сан	Баянгол дүүргийн 18 дугаар хороо, 4-р хороолол Соёмбо таурын 1 давхарт
3.	Эсүн дентал студи ХХК /7178649/	Клиник	Нүүр амны өвчний оношилгоо, эмчилгээ, нүүр амны согог, гажиг засал, нүүр амны мэс засал	ХУД 18-р хороо, Юник төв /61 байр/ 2 давхар 202,203, 204 тоот

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 09 дүгээр сарын 16 ны өдрийн
4/884 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛӨХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮР ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
ХУУЛИЙН ЭТГЭЭД

Д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр /регистрийн дугаар/	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үндэслэл
1.	Эв эрдэнэ ХХК	Эмийн сан	ЭСХ-03/22/2169	Өөрийн хүсэлтээр
2.	Их цэцэгт нуга ХХК	Эмийн сан	ЭСХ-17/22/2597	Зөвшөөрлийн тухай хуулийн зургадугаар бүлгийн 6.1 дүгээр зүйлийн 1.1